

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2024 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2025/113/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Мөрөн сум

2025 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах удитор: Б.Давааням

Утас:88095436 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа

Утас:99389208 Цахим хаяг: b_myadagmaaa@yahoo.com

Аудитор Ц.Мөнхтуяа

Утас: 99382220 Цахим хаяг: munkhtuya2220@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 1/226
Танай _____ -ны № _____ -г

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэг нь 2024 онд Эрүүл мэндийн даатгалын сангаас 19,517,814.6 мянган төгрөгийн санхүүжилтийг авахаас 18,560,887.1 мянган төгрөгийг санхүүжилтийг авч 1,543,132.3 мянган төгрөгийн авлагатай гарсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар тайлант жилийн төсөвт орсон өөрчлөлтийг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилт, төлбөр тооцооны системд дотоод хяналтыг хангалттай хэрэгжүүлээгүй, нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад урамшуулал олгохдоо холбогдох шалгуур үзүүлэлтүүдийг харгалзаж үзээгүй, бараа материалын үлдэгдэлд хугацаа дууссан болон зах зээлийн үнээс хэт доогуур үнэлгээтэй хөрөнгө бүртгэлтэй зэрэг зөрчил илэрсэн.

Бусад асуудлын хэсэг

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэгтэй байгуулсан лавлагаа шатлалын тусламж үйлчилгээг худалдан авах 2024 оны гэрээний биелэлтийг 87.0 хувьтай дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,628,504,252.06	3,291,247,284.90
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	11,647,106.51	86,253,739.17
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	11,647,106.51	86,253,739.17
3121	Төгрөг	11,647,106.51	86,253,739.17
31211	Төрийн сангийн харилцах	11,647,106.51	86,253,739.17
33	АВЛАГА	586,818,252.41	1,547,104,237.11
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	586,204,820.00	1,543,132,264.70
335	Бусад авлага	613,432.41	3,971,972.41
3351	Байгууллагаас авах авлага	613,432.41	1,237,672.41
3352	Хувь хүмүүсээс авах авлага	00.00	2,734,300.00
35	БАРАА МАТЕРИАЛ	2,030,038,893.14	1,657,889,308.62
351	Түүхий эд материал	1,439,249,356.56	1,031,692,962.05
35110	Тусгай зориулалттай материал	221,568,582.02	255,568,727.80
35130	Эм боох материал	1,217,680,774.54	776,124,234.25
354	Хангамжийн материал	590,789,536.58	626,196,346.57
35410	Бичиг хэргийн материал	796,660.00	1,099,150.00
35420	Аж ахуйн материал	117,424,929.13	105,571,935.01
35430	Сэлбэг хэрэгсэл	9,788,400.00	37,585,600.00
35440	Түлш, шатах тослох материал	497,124.60	2,092,790.00
35450	Барилгын засварын материал	3,443,500.00	5,593,650.00
35460	Хүнсний материал	12,768,646.50	17,115,337.00
35470	Бусад хангамжийн материал	446,070,276.35	457,137,884.56
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	16,331,970,639.54	17,522,587,432.45
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	16,331,970,639.54	17,522,587,432.45
392	Биет хөрөнгө	15,204,744,389.62	16,396,674,307.53
39201	Барилга, байгууламж, орон сууц	9,516,915,562.13	10,190,774,265.13
39202	Хуримтлагдсан элэгдэл	-2,109,683,356.24	-2,585,074,460.32
39203	Авто-тээврийн хэрэгсэл	703,237,673.00	1,201,787,595.20
39204	Хуримтлагдсан элэгдэл	-298,919,833.63	-445,548,745.99
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	11,438,046,525.41	13,331,584,608.54
39206	Хуримтлагдсан элэгдэл	-4,526,046,685.97	-5,707,286,308.61
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	705,199,629.32	660,950,880.67
39208	Хуримтлагдсан элэгдэл	-296,905,320.56	-307,678,269.53
39214	Бусад үндсэн хөрөнгө	154,208,413.40	154,208,413.40
39215	Хуримтлагдсан элэгдэл	-81,308,217.24	-97,043,670.96
393	Биет бус хөрөнгө	1,127,226,249.92	1,125,913,124.92
39303	Бусад биет бус хөрөнгө	1,128,432,500.00	1,128,432,500.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-1,206,250.08	-2,519,375.08
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	18,960,474,891.60	20,813,834,717.35
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,311,959,941.63	1,473,450,366.04
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,311,959,941.63	1,473,450,366.04
413	Өглөг	1,311,959,941.63	1,473,450,366.04
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,311,693,956.63	1,473,450,366.04
4136	Бусад өглөг	265,985.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	265,985.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	17,648,514,949.97	19,340,384,351.31

51	Засгийн газрын хувь оролцоо	17,648,514,949.97	19,340,384,351.31
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	7,126,931,228.10	7,126,931,228.10
51101	Өмч: - төрийн	7,126,931,228.10	7,126,931,228.10
512	Хуримтлагдсан үр дүн	6,102,484,408.15	7,794,353,809.49
51210	Өмнөх үеийн үр дүн	6,102,484,408.15	6,102,484,408.15
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	1,691,869,401.34
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,419,099,313.72	4,419,099,313.72
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	18,960,474,891.60	20,813,834,717.35

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	18,100,453,409.66	26,326,571,915.35
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,744,260,939.66	5,076,723,238.35
120	Нийтлэг татварын бус орлого	1,744,260,939.66	5,076,723,238.35
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	426,425,387.00	1,091,171,236.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	426,425,387.00	834,825,036.00
1200042	Туслах ажиллагааны орлогоос санхүүжих		256,346,200.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,317,835,552.66	
122	Тусламжийн орлого	00.00	3,985,552,002.35
1200017	үнэ төлбөргүй хүлээн авсан /УХ	00.00	3,720,212,265.34
1200018	үнэ төлбөргүй хүлээн авсан /БМ	00.00	265,339,737.01
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	16,356,192,470.00	21,249,848,677.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,516,900.00	00.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	00.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,516,900.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	1,732,034,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	1,732,034,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	16,351,675,570.00	19,517,814,577.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	16,351,675,570.00	19,517,814,577.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	20,217,043,638.46	24,595,257,744.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	20,217,043,638.46	24,595,257,744.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	20,207,940,658.46	24,332,204,146.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,722,138,057.79	12,398,451,105.84
210101	Үндсэн цалин	4,709,093,099.92	5,744,381,291.45
210102	Нэмэгдэл	3,602,281,437.28	4,725,537,201.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	610,898,399.43	689,055,872.00
210104	Урамшуулал	746,945,121.16	1,239,476,741.23
210105	Гэрээт ажлын хөлс	52,920,000.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,233,045,667.33	1,598,681,863.40
210201	Тэтгэврийн даатгал	862,569,993.23	1,193,466,252.01
210202	Тэтгэмжийн даатгал	92,415,614.64	101,230,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	73,558,431.56	50,908,111.39
210204	Ажилгүйдлийн даатгал	18,201,146.38	50,615,400.00

210205	Эрүүл мэндийн даатгал	186,300,481.52	202,461,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,671,582,693.54	1,571,384,717.49
210301	Гэрэл, цахилгаан	145,273,515.93	171,758,885.81
210302	Түлш, халаалт	1,000,021,985.46	877,692,564.33
210303	Цэвэр, бохир ус	524,579,392.15	521,933,267.35
210304	Байрны түрээс	1,707,800.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	321,920,677.89	913,758,826.91
210401	Бичиг хэрэг	18,669,460.00	16,706,045.00
210402	Тээвэр, шатахуун	101,465,138.65	98,784,410.60
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17,563,563.00	21,183,270.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,370,000.00	9,750,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	62,340,730.93	67,751,595.71
210408	Бараа материал акталсны зардал	114,511,785.31	699,583,505.60
2105	Нормативт зардал	4,514,458,207.94	4,747,834,602.07
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,329,644,163.94	4,552,739,204.37
210502	Хоол, хүнс	184,814,044.00	195,095,397.70
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	204,967,494.27	437,156,690.00
210604	Урсгал засвар	204,967,494.27	437,156,690.00
2107	Томилолт, зочны зардал	27,516,000.00	36,708,400.00
210702	Дотоод албан томилолт	27,516,000.00	36,708,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	139,314,539.00	105,603,038.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	115,940,506.00	68,767,181.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,660,000.00	2,660,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	96,525.00	6,159,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	745,428.00	540,033.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	330,000.00	242,000.00
210807	Газрын төлбөр	6,674,055.00	6,674,102.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	12,868,025.00	20,560,322.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,372,997,320.70	2,522,624,902.47
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,245,085.00	21,474,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,351,752,235.70	2,501,150,702.47
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,102,980.00	263,053,597.87
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,102,980.00	252,283,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	228,450,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,102,980.00	23,833,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	10,770,097.87
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		10,770,097.87
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-2,116,590,228.80	1,731,314,171.30
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	00.00	00.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	43,333.52	39,444,769.96
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	43,333.52	39,444,769.96
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-43,333.52	-39,444,769.96
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-2,116,633,562.32	1,691,869,401.34

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	16,198,945,414.81	21,381,878,168.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	428,957,764.81	1,088,956,936.00
120	Нийтлэг татварын бус орлого	428,957,764.81	1,088,956,936.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	428,957,764.81	1,088,956,936.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	428,957,764.81	832,610,736.00
1200042	Туслах ажиллагааны орлогоос санхүүжих		256,346,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	15,769,987,650.00	20,292,921,232.30
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,516,900.00	00.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	00.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,516,900.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	1,732,034,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	1,732,034,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	15,765,470,750.00	18,560,887,132.30
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	15,765,470,750.00	18,560,887,132.30
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	16,112,040,832.30	21,296,271,535.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	16,112,040,832.30	21,296,271,535.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16,102,937,852.30	21,033,217,937.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,699,206,057.79	12,372,929,169.04
210101	Үндсэн цалин	4,709,093,099.92	5,718,859,354.65
210102	Нэмэгдэл	3,602,281,437.28	4,725,537,201.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	587,966,399.43	689,055,872.00
210104	Урамшуулал	746,945,121.16	1,239,476,741.23
210105	Гэрээт ажлын хөлс	52,920,000.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,233,045,667.33	1,598,681,863.40
210201	Тэтгэврийн даатгал	862,569,993.23	1,193,466,252.01
210202	Тэтгэмжийн даатгал	92,415,614.64	101,230,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	73,558,431.56	50,908,111.39
210204	Ажилгүйдлийн даатгал	18,201,146.38	50,615,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	186,300,481.52	202,461,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,050,525,438.40	2,192,441,972.63
210301	Гэрэл, цахилгаан	145,273,515.93	171,758,885.81
210302	Түлш, халаалт	512,051,046.32	1,365,663,503.47
210303	Цэвэр, бохир ус	391,493,076.15	655,019,583.35
210304	Байрны түрээс	1,707,800.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	262,826,621.50	217,745,976.00
210401	Бичиг хэрэг	18,837,400.00	17,185,885.00
210402	Тээвэр, шатахуун	101,038,863.50	99,274,328.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17,563,563.00	21,183,270.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,370,000.00	9,750,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	118,016,795.00	70,352,493.00

2105	Нормативт зардал	3,474,895,267.28	4,029,363,793.70
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,191,711,807.32	3,784,399,768.70
210502	Хоол, хүнс	206,594,310.00	224,964,025.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	76,589,149.96	20,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	194,555,176.00	458,180,890.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,506,720.00	595,000.00
210604	Урсгал засвар	193,048,456.00	457,585,890.00
2107	Томилолт, зочны зардал	27,516,000.00	36,708,400.00
210702	Дотоод албан томилолт	27,516,000.00	36,708,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	139,388,524.00	105,425,688.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	115,940,506.00	68,767,181.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,660,000.00	2,660,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	96,525.00	6,159,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	745,428.00	540,033.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	330,000.00	242,000.00
210807	Газрын төлбөр	6,674,055.00	6,674,102.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	12,942,010.00	20,382,972.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,979,100.00	21,740,185.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,979,100.00	21,740,185.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,102,980.00	263,053,597.87
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,102,980.00	252,283,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	228,450,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,102,980.00	23,833,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	10,770,097.87
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		10,770,097.87
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	86,904,582.51	85,606,632.66
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	197,364,720.00	11,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	197,364,720.00	11,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	197,364,720.00	11,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	197,364,720.00	11,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-197,364,720.00	-11,000,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-110,460,137.49	74,606,632.66
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	122,107,244.00	11,647,106.51
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	11,647,106.51	86,253,739.17

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	7,126,931,228.10	4,419,099,313.72	8,219,117,970.47	19,765,148,512.29
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-2,116,633,562.32	-2,116,633,562.32

2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,126,931,228.10	4,419,099,313.72	6,102,484,408.15	17,648,514,949.97
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	7,126,931,228.10	4,419,099,313.72	6,102,484,408.15	17,648,514,949.97
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,126,931,228.10	4,419,099,313.72	6,102,484,408.15	17,649,260,949.97
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,691,869,401.34	1,691,123,101.34
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,126,931,228.10	4,419,099,313.72	7,794,353,809.49	19,340,384,351.31

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Улсын төсвийн гүйцэтгэл:

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	19,811,862,900.00	19,575,237,435.64	98.81	236,625,464.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	19,811,862,900.00	19,575,237,435.64	98.81	236,625,464.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	19,488,682,900.00	19,322,953,935.64	99.15	165,728,964.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	12,642,351,700.00	12,372,929,169.04	97.87	269,422,530.96
210101	Үндсэн цалин	5,716,981,200.00	5,718,859,354.65	100.03	(1,878,154.65)
210102	Нэмэгдэл	5,283,225,200.00	4,725,537,201.16	89.44	557,687,998.84
210103	Унаа хоолны хөнгөлөлт	662,425,000.00	689,055,872.00	104.02	(26,630,872.00)
210104	Урамшуулал	979,720,300.00	1,239,476,741.23	126.51	(259,756,441.23)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,607,004,400.00	1,598,681,863.40	99.48	8,322,536.60
210201	Тэтгэврийн даатгал	1,202,081,500.00	1,193,466,252.01	99.28	8,615,247.99
210202	Тэтгэмжийн даатгал	101,230,700.00	101,230,700.00	100.00	0.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	50,615,400.00	50,908,111.39	100.58	(292,711.39)
210204	Ажилгүйдлийн даатгал	50,615,400.00	50,615,400.00	100.00	0.00
210205	Эрүүл мэндийн даатгал	202,461,400.00	202,461,400.00	100.00	0.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	633,086,400.00	495,672,620.50	78.29	137,413,779.50
210302	Түлш, халаалт	500,000,000.00	362,586,295.15	72.52	137,413,704.85
210303	Цэвэр, бохир ус	133,086,400.00	133,086,325.35	100.00	74.65
2104	Хангамж, бараа материалын зардал	243,817,900.00	217,745,976.00	89.31	26,071,924.00
210401	Бичиг хэрэг	19,240,000.00	17,185,885.00	89.32	2,054,115.00
210402	Тээвэр, шатахуун	101,111,800.00	99,274,328.00	98.18	1,837,472.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	22,656,300.00	21,183,270.00	93.50	1,473,030.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,328,000.00	9,750,000.00	117.07	(1,422,000.00)
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	92,481,800.00	70,352,493.00	76.07	22,129,307.00
2105	Нормативт зардал	3,608,852,000.00	4,029,363,793.70	111.65	(420,511,793.70)
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,367,522,800.00	3,784,399,768.70	112.38	(416,876,968.70)
210502	Хоол, хүнс	236,329,200.00	224,964,025.00	95.19	11,365,175.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,000,000.00	20,000,000.00	400.00	(15,000,000.00)
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	590,773,400.00	444,686,240.00	75.27	146,087,160.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	159,399,500.00	11,595,000.00	7.27	147,804,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	6,848,900.00	0.00	0.00	6,848,900.00
210603	Хөдөлмөр хамгаалалын хэрэгсэл	6,848,900.00		0.00	6,848,900.00
210604	Урсгал засвар	424,525,000.00	433,091,240.00	102.02	(8,566,240.00)

2107	Томилолт, зочны зардал	36,708,400.00	36,708,400.00	100.00	0.00
210702	Дотоод албан томилолт	36,708,400.00	36,708,400.00	100.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	104,312,400.00	105,425,688.00	101.07	(1,113,288.00)
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	69,167,800.00	68,767,181.00	99.42	400,619.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,660,000.00	2,660,000.00	100.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	6,159,400.00	6,159,400.00	100.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	584,800.00	540,033.00	92.34	44,767.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	363,000.00	242,000.00	66.67	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	474,000.00	0.00	0.00	474,000.00
210806	Мэдээлэл технологийн зардал	474,000.00		0.00	474,000.00
210807	Газрын төлбөр	4,123,400.00	6,674,102.00	161.86	(2,550,702.00)
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,113,300.00	0.00	0.00	1,113,300.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	20,780,000.00	20,382,972.00	98.09	397,028.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,776,300.00	21,740,185.00	99.83	36,115.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,776,300.00	21,740,185.00	99.83	36,115.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	323,180,000.00	252,283,500.00	78.06	70,896,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	323,180,000.00	252,283,500.00	78.06	70,896,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	300,000,000.00	228,450,000.00	76.15	71,550,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	23,180,000.00	23,833,500.00	102.82	(653,500.00)
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	19,811,862,900.00	19,649,844,068.30	99.18	162,018,831.70
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	18,582,675,000.00	18,560,887,132.30	99.88	21,787,867.70
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	18,582,675,000.00	18,560,887,132.30	99.88	21,787,867.70
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,229,187,200.00	1,088,956,936.00	88.59	140,230,264.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	701,074,200.00	832,610,736.00	118.76	(131,536,536.00)
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	526,849,100.00	256,346,200.00	48.66	270,502,900.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	1,264,600.00	0.00	0.00	1,264,600.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	11,647,106.51		(11,647,106.51)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	86,253,739.17		(86,253,739.17)

Орон нутгийн төсвийн гүйцэтгэл:

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,732,034,100.00	1,721,264,002.13	99.38	10,770,097.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,732,034,100.00	1,721,264,002.13	99.38	10,770,097.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,732,034,100.00	1,721,264,002.13	99.38	10,770,097.87
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,707,034,100.00	1,696,769,352.13	99.40	10,264,747.87
210301	Гэрэл, цахилгаан	171,151,400.00	171,758,885.81	100.35	(607,485.81)
210302	Түлш, халаалт	1,003,077,600.00	1,003,077,208.32	100.00	391.68
210303	Цэвэр, бохир ус	532,805,100.00	521,933,258.00	97.96	10,871,842.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,000,000.00	24,494,650.00	97.98	505,350.00
210604	Урсгал засвар	25,000,000.00	24,494,650.00	97.98	505,350.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,732,034,100.00	1,721,264,002.13	99.38	10,770,097.87
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,532,034,100.00	1,721,264,002.13	112.35	(189,229,902.13)
320001	Орон нутгийн төсвөөс	1,532,034,100.00	1,721,264,002.13	112.35	(189,229,902.13)
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	200,000,000.00			200,000,000.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 27,488.0 мянган төгрөгийн 8 алдаа, зөрчил илэрснээс, 7 зөвлөмж өгч, 1 алдааг залруулсан.

3.1 Залруулсан алдаа

- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөөний нийт эх үүсвэрийн дүнг тааруулаагүй, урьд оны үлдэгдлээс санхүүжих 1,264.6 мянган төгрөгийг орхигдуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх;” заалттай нийцэхгүй “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад залруулсан.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 26,223.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 323,472.7 мянган төгрөгөөс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус эмнэлгийн бараа материалын үлдэгдэлд зах зээлийн үнээс хэт доогуур үнэлгээтэй хөрөнгүүд бүртгэлтэй, тухайлбал 1.0 мянган төгрөгөөс доош үнийн дүн бүхий 211.7 мянган төгрөгийн 163 хөрөнгө бүртгэлтэй, хугацаа дууссан 3,126.7 мянган төгрөгийн бараа материал бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” заалттай нийцэхгүй “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бараа материалын үлдэгдэлд байгаа зах зээлийн үнээс хэт доогуур үнэтэй, олон жил ашигласан хөрөнгүүдийн чанарт үнэлгээ өгч, үнэлгээг шинэчлэн тогтоох, хугацаа дуусан бараа материалыг зохих журмын дагуу данснаас хасах.

2. Нягтлан бодох бүртгэлийн ажилтны урамшууллын талаар

Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад урамшуулал олгохдоо холбогдох шалгуур үзүүлэлтүүдийг харгалзаж үзээгүй, зөвхөн "Зөрчилгүй" санал дүгнэлт авсан гэсэн ганц шалгуураар 22,885.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23.2 заалт, Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалаар баталсан журмын 5.1 заалтад заасан шалгуур үзүүлэлт, Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4 заалтад заасан "Үр дүнгийн гэрээний биелэлт, хэрэгжилтийн явц байдалд үндэслэн...", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3-р хавсралт "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2.1 заалтад "төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид," мөнгөн урамшуулал олгохоор заасантай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад урамшуулал олгохдоо аудитын тайланд бичигдсэн болон бусад хяналтын байгууллагаас илрүүлсэн алдаа, зөрчил, өр, авлага, мэдээ, тайлангийн хугацаа, чанар зэрэг үзүүлэлтийг харгалзаж үзэх.

3. Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийн асуудал

Илрүүлэлт:

2024 онд 21,071,165.9 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас нэхэмжилснээс 1,553,348.4 төгрөг хасагдсан нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6 "эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх;" Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны "Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" 06 дугаар тогтоолтой тус тус нийцэхгүй "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны цахим системийн дотоод хяналтыг сайжруулж, хасагдалтын хэмжээг өмнөх оноос бууруулах.

4. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант жилийн төсөвт орсон өөрчлөлтийг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.", 48 дугаар зүйлийн 48.2.1 "Худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт багтаан хуульд заасан хугацаанд зохион байгуулах;" Сангийн сайдын 2023 оны А/250 тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2.11 "Захиалагч цахим системд нийтэлсэн төлөвлөгөөг мөрдөж ажиллах ба энэ журмын 2.12-т заасан үндэслэлээр батлагдсан төлөвлөгөөнд орсон нэмэлт, өөрчлөлтийг холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын 10 өдөрт багтаан төлөвлөгөөнд өөрчлөлтийг тусган, батална. Хэрэв холбогдох дээд шатны байгууллага

байгаа бол төлөвлөгөөний өөрчлөлтийг түүгээр батлуулахаар цахим системээр илгээж, өөрчлөлтийг баталгаажуулна.” гэж заасантай нийцэхгүй “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Тайлант оны төсөвт батлагдсан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг төлөвлөх, өөрчлөлт орсон тухай бүрд нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусган батлуулах.

5. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус нэгдсэн эмнэлэг нь Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим 5 сая төгрөгийн үнийн дүн бүхий орлогын 8,300,074.1 мянган төгрөгийн 26 гүйлгээ, зарлагын 1,743,918.7 мянган төгрөгийн 79 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжид нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

6. Ахмадын сангийн талаар

Илрүүлэлт:

Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэг нь ахмадын сан байгуулаагүй байгаа нь Ахмадын настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 “Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулах...” гэж заасантай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Ахмадын санг байгууллагын төсөвт тусгаж батлуулах, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан журмыг мөрдөж ажиллах

7. Нэгдсэн эмнэлгийн ТУЗ-ийн үйл ажиллагааны талаар

Илрүүлэлт:

Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлгийн ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн даргын цалин, урамшууллыг Нэгдсэн эмнэлгийн даргын тушаалаар тогтоосон, ТУЗ нь 2024 оны төсвийн төслийг хэлэлцэх, төлөвлөгөөний хуваарь батлах, цалингийн сан, орон тоог батлахтай холбоотой зөрчлүүд нь Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.10.3 “эмнэлгийн тухайн жилийн төсвийн төслийг хэлэлцэх, төсвийн хуваарилалтыг батлах;”, 17.10.4 “төсвийн хязгаарт нийцүүлэн эмнэлгийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаар, цалингийн санг тогтоох;”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.1 заалт “төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх;” заалтууд болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

ТУЗ-ын үйл ажиллагаанд холбогдох хууль, эрх зүйн актуудыг мөрдөж ажиллах

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган

төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөөнд урьд оны үлдэгдлээс санхүүжих дүнг орхигдуулсан.	1	1,264.6			1	1,264.6	1	1,264.6		
Дүн	1	1,264.6		-	1	1,264.6	1	1,264.6		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зах зээлийн үнээс хэт доогуур үнэтэй, хугацаа дууссан бараа материал бүртгэлтэй байна.	1	3,338.4						1	3,338.4
Бүртгэлийн ажилтнуудад урамшуулал олгохдоо холбогдох шалгуур үзүүлэлтүүдийг харгалзаж үзээгүй, зөвхөн "Зөрчилгүй" санал дүгнэлт авсан гэж урамшуулсан байна.	1	22,885.0						1	22,885.0
Дүн	2	26,223.4						2	26,223.4

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны цахим хуудсанд холбогдох мэдээллүүдийг хугацаа хоцроож мэдээлсэн.	1	-						1	-
Тайлант жилийн төсөвт орсон өөрчлөлтийг тусгаж худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулаагүй.	1	-						1	-
Эмнэлгийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийг цахим системд бүрэн, үнэн зөв оруулаагүйгээс нэхэмжилсэн санхүүжилтийг бүрэн авч чадаагүй.	1	-						1	-
ТУЗ Эрүүл мэндийн тухай хуулийн 17.10.3, 17.10.4 заалтыг буруу хэрэгжүүлсэн	1	-						1	-
Ахмадын санг байгууллагын төсөвт тусгаж, батлуулаагүй	1	-						1	-
Дүн	5	-						5	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			